

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Тариалан, Түнэл, Рашаант, Мөрөн, Тосонцэнгэл, Их-Уул сумдад Хөдөлмөрийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулж, гарын авлага тараах материал тараав.

Мөн Монголын Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчийн пробано өдөр”-ийг тохиолдуулан аймгийн хууль хяналтын байгууллагуудыг оролцуулан нээлттэй хаалганы өдрийг “Шинэ Мөрөн” ХҮТ-д зохион байгуулж, иргэдэд анхан шатны төрийн үйлчилгээг үзүүлж, 68 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр :

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт хоолны хордлогын шинж тэмдэгтэй 3 хүн ирсэн. Асуумж авахад Мөрөн сумын 8-р багт байрлах Хөвсгөл өргөө ХХК-ний “Өргөө” зоогийн газраас ажлын 8 хүн хоол идсэн байна гэсэн Нэгдсэн эмнэлгийн тархвар судлагч их эмчийн мэдээллийн дагуу тус байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж хүнсний бүтээгдэхүүн түүхий эдээс 6 дээж, ундны уснаас 1 дээж, ажилчдын хувцас, гар, тоног төхөөрөмжийн гадаргуугаас нийт 27 арчдас авч мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторийн нян судлалын шинжилгээний хариу болон эрүүл мэндийн байгууллагаас өвчтөнүүдээс хийсэн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн “Шигела”нянгаар үүсгэгдсэн хоолны хордлого болохыг эрүүл мэндийн газрын тархвар судлаач их эмчийн дүгнэлтээр батлагдсан. Хөвсгөл өргөө ХХК-нй үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоож зөрчлийг арилгуулж, 1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй 6 иргэний ажлын байрыг үзэж зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллав.

Мөрөн сумын хэмжээнд 16 хүнсний бөөний төвд хүнсний түргэн муудах бараа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийж ажиллаа.

Байгаль орчны хяналтын чиглэлээр:

Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллаа.

Түнэл,Тосонцэнгэл сумдын нутаг дэвсгэрт хулгайн ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулав.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:

МХЕГазрын даргын 2022-оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/63 удирдамжаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилт, тулгамждаж буй асуудалд тандалт судалгаа хийж байна.

Мөн МХЕГазрын даргын 2022 оны 1/91 дүгээр удирдамжийн хүрээнд туслах малчин, морь унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлд хяналт шинжилгээг хийж ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн хяналтын чиглэлээр: Аймгийн хэмжээнд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажилд мал эмнэлгийн хяналтыг тавьж ажиллав.

Хяналтын ажлын хэсэгт мэргэжлийн хяналтын 5 улсын байцаагч орж ажиллаж 23 сумын 1 тосгоны нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажлыг хийж ажиллаж вакцинжуулалт аймгийн хэмжээнд 94,5 хувьтай хийгдэж дууслаа.

Хаврын газар тариалангийн ажил эхэлж байгаатай холбогдуулан тариалан эрхлэгч иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын тариалалтын үрийг лабораторийн шинжилгээнд хамруулж ажиллаж байна.

Онцгой байдлын чиглэлээр:

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа:

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/117 дугаар тоот “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай ” захирамжийн хүрээнд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газрын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж 5 чиглэлд үүрэг гүйцэтгэв.

Сумдын Онцгой Комиссыг хуралдуулж зарим вакцин хийж буй багуудад хүрэлцэн очиж вакцины хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, тарилгын явцад технологийн алдаа гарч байгаа эсэх, орхигдсон айл, өрх, мал байгаа эсэх, тухайн сум багийн нутаг дэвсгэрт отрын мал байгаа эсэх вакцин хийсэн эсэхэд хяналт тавьж ажилласан.

Вакцин хийгдсэн малчин өрхүүдэд 28 хоног дотор шилжилт хөдөлгөөн хийхгүй байх талаар ухуулаг яриа хийсэн.

Мөн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчийн 10 дугаартай Заавал биелүүлэх албан шаардлагын хүрээнд сумын Шуурхай штабыг байгуулах, хийгдсэн ажлын мэдээ тайланг аймгийн шуурхай штабт өдөр бүр тогтоосон цагт хүргүүлж байх талаар заавар өгсөн.

Улсын Онцгой комиссын 2022 оны 02 тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байсан тул хугацаатай үүрэг өгч ажилласан.

Цагааннуур сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 41 дүгээр албан бичгийн хүрээнд Хармай 2 дугаар багийн “Хар адар” гэдэг газар 15 цаачин өрхүүдийн 100 гаран цаа буга цасан нуранганд дарагдсан ослын голомт дээр ажиллав.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн хүрээнд Мөрөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх станцуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг 6 шатахуун түгээх станц дээр явуулж 29 зөрчил илрүүлж 8 зөрчлийг газар дээр нь арилгуулж 21 зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн “Заавал биелүүлэх албан шаардлага”-3, Мэдэгдэл 3 үйлдэж хугацаатай үүрэг даалгавар өгөв.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны хэмжээнд үер усны холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, үүссэн цагийн байдал дээр ажиллах ажлын хэсгийн багаж зэвсэглэмжийн болон хувийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллах үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1 дахь заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн эрсдэлийн үнэлгээний газартай хамтарч Ханх, Хатгал сумдад Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Мөрөн, Чандмань-Өндөр, сумдад Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтарч Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдад гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийв.

Цагаан-Уул сумын төвийн баруун болон төвийн хэсэгт 3.5 км урттай 1,5 метрийн өндөртэй шороон далан байгууламжийн зураг төслийг зам гүүр, барилга угсралтын “Мөнхийн зам” ХХК-иар хийлгэв. 2023 онд тухайн шороон далан байгууламжийн хийхээр төлөвлөж байна.

Мөн Мөрөн сумын 1, 2, 7, 13 дугаар багийн үерийн ус зайлуулах 5 км замын зураг төсвийг хийлгэж 2022 оны 3 дугаар улиралд хийлгэх 150.000.000 (Нэг зуун тавин сая) төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллав.

Бүрэнтогтох сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/98 дугаар албан бичгийн хүрээнд Бүрэнтогтох сумын Их-Уул багийн “Боом”-ын давааны зам засварын зураг төсөлд хянан баталгаа хийв.

Бэлтгэл бэлэн байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа:

2022 оны 04 дүгээр сарын байдлаар Хөвсгөл аймагт 6 удаагийн объектын гал түймэр, 2 удаагийн зөрчлийн дуудлага гарсан байна. Тус дуудлагаар Онцгой байдлын байгууллага гал түймрийн аюулаас иргэн, аж ахуй нэгж байгууллагын 146,000,000 / зуун дөчин зургаан сая төгрөг /-ний эд хөрөнгийг авран хамгаалсан байна. Гал түймрийн улмаас 5,400,000 / таван сая дөрвөн зуун мянган төгрөг /-ний хохирол учирсан байна.

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд газар хөдлөлтийн тохиолдол 2 сумын нутагт 4 суманд 3 удаа, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин 13 сумын нутагт 13 голомт, усны холбогдолтой осол 1 сумын нутагт 1 удаа тохиолдсон техникийн холбогдолтой осол 1 сумын нутагт 1 удаа тус тус тохиолдсон ба 2021 оны мөн онтой харьцуулахад мал, амьтны гоц халдварт өвчний тохиолдол 70% өсч бусад гамшиг осол 10 % буурсан байна.

Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид шуурхай албаны 42-44 ХӨҮ Пургон автомашинд ачаа хийж суурилуулах, нум сольж, арын хаалга, хананд нимгэн төмрөөр бүрэх, урд 2 дугуйнд шаврын хаалт хийх, бүх гал хамгаалагчийг сольж албаны бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Санхүү, аж ахуйн бодлого зохицуулалт

Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хуулийн хууль тогтоомж зөрчсөн 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дахь заалтын дагуу тус бүрд нь 500.000 (Таван зуун мянган) төгрөгийн захиргааны арга хэмжээ авч орон нутгийн орлогод төвлүүлэн ажилласан байна.

Галын аюулгүй байдлын тухай хууль, зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 5 иргэнийг 500,000 /таван зуун мянган төгрөг /-ний торгуулийн арга хэмжээ авч, Галын аюулгүй байдлын тухай хууль, улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4 дахь заалтын дагуу 26 аж ахуйн, нэгж байгууллага, иргэнд ажлын байрны аюулгүй байдлын дүгнэлт олгож, барилгын зураг төсөл 6 хянаж орон нутгийн орлогод нийт 812,000 /найман зуун арван хоёр мянган төгрөг/-ний орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлангийн хугацаанд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-10, мэдэгдэл-10, гал түймэр гарсан тухай акт 4 зэрэг эрх зүйн бичиг баримт үйлдэн ажилласан байна.

2022 оны 04 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны сайт, ил тодын буланд байршуулж удирдлага болон алба хаагч, ард иргэдэд санхүүгийн үнэн зөв мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2022 оны 04-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **12.0** тэрбум төгрөгний **2093** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2022 оны 03-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 15,517.1 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 16,625.9 сая төгрөг буюу 107.1% хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2022 оны 03-р сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 39,327.5 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 1,489.6 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 1,233.4 сая төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлогоос, 7,677.7 сая төгрөг нь аймаг нийслэлээс авсан санхүүжилт, 24,766.4 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 2,345.4 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 9,045.7 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 39,327.5 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 35,424.7 мянган төгрөг буюу 90.0 % хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **3,813.7** сая төгрөг өмнөх сараас **20.2** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **1,319.9** сая төгрөг өмнөх сараас **574.4** сая төгрөгөөр өссөн.

Нийгмийн даатгалын хэлтсийн сарын шуурхай мэдээ:

2022 оны 04 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 2127.2 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 359.9 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 96.8 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2363.3	1963.3	83.1
Тэтгэмж	232.7	187.6	80.6
ҮОМШӨ	166.1	116.8	70.3
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	43.9	34.3	78.1
дүн	2806	2302	78.0

Тэтгэврийн даатгалын сангаас 21114 тэтгэвэр авагч 10780 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 1065 даатгуулагчдад 277.7 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 179 даатгуулагчдад 73.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 818.8 сая төгрөг байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Хөвсгөл аймгийн ЗДТГ, БШУГ, Хэлний бодлогын Хөвсгөл аймгийн салбар зөвлөл хамтран, “Монгол хэлний тухай хууль”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ыг хэрэгжүүлэх, Хөвсгөл аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Эрхэм баян эрдэм” зорилт, 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөхөд бэлтгэлийг хангах, “Төрийн албан хаагчдын хэл, бичгийн боловсролыг дээшлүүлэх” үйл ажиллагааны хүрээнд Хөвсгөл аймгийн хэмжээнд “ЭХ ХЭЛ БИДНИЙ БАХАРХАЛ” аяныг зохион байгууллаа.

Боловсролын салбарын удирдлагуудад ёс зүйт манлайллыг төлөвшүүлж, өөрийн сургуулийн багш, ажиллагсад болон бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйн дүрэм, хэм хэмжээг баримтлан ажиллах, мөрдөн хэрэгжүүлэх арга зүй, менежментэд суралцах, боловсролын салбарын шинэчлэлтэй биечлэн танилцах, туршлага судлах, сургалт, үйл ажиллагааг УИХ-ын гишүүн, БШУЯ-ны сайд Л.Энх-Амгалангийн санаачилга, дэмжлэгтэйгээр "Ёс зүйт манлайлал" сэдвийн дор Улаанбаатар хотод зохион байгуулж Хөвсгөл аймгийн 65 захирал, эрхлэгч оролцлоо.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн санаачилга, дэмжлэгээр хэрэгжиж буй “Шинэ ЭГЭЛ арга зүйгээр хичээлийн хоцрогдлыг арилгах нь” төсөл – сургалт зохион байгуулагдлаа.

Улсын төрөлжсөн хичээлийн олимпиадын 2-н даваа зохион байгуулагдаж, тус олимпиадад 8 мэргэжлийн чиглэлээр 300 гаруй багш 1200 гаруй сурагч оролцож мэдлэг чадвараа сорин өрсөлдөв.

2021-2022 оны хичээлийн жилийн “ОНЫ ШИЛДЭГ ИЛТГЭЛ” шалгаруулах улсын уралдаанд Хөвсгөл аймгийн Титэм ЕБС-ийн Түүх, нийгмийн ухааны ЗАН-ийн багш нар “Багшлахуйн залгамж холбоо” илтгэлээрээ амжилттай оролцож III байранд шалгарч Хүрэл медаль хүртлээ.

Боловсрол шинжлэх ухааны газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын Хөвсгөл орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран аймгийн нийт 39 дотуур байрын 75 багшид “Эерэг хүмүүжлийн арга” сургалтыг зохион байгуулав.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 сарын 21-ны өдрийн А/190-р тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”-д туссан үйл ажиллагааг сум, орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхэд ахмад багш нартайгаа хамтран ажиллах, сургалтын байгууллагын “Ахмадын зөвлөл”-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Ахмад багш нарын дэмжлэгийн баг” ажиллуулах журам батлан хэрэгжилтийг хангуулж эхэллээ.

Medle.mn платформ дээр “Ээлжит хичээлийн цахим контент” боловсруулах сургалтыг Боловсролын мэдээллийн технологийн төвийн дэргэдэх зөвлөх баг “Хичээлийн контент боловсруулж, сан бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцох арга зүй”-н агуулгаар танхимын сургалтыг зохион байгууллаа.

Боловсролын сэтгэл зүйчийн үйл ажиллагааны явц, ажлын байранд үнэлгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйчийн үйл ажиллагааг тогтворжуулах зөвлөн туслах ажил БШУЯ, БЕГ, Сэтгэл зүйчдын нийгэмлэгээс хамтарсан баг Авьяас, ДМЦС, ЭДЦС, Рашаант, Хатгал сумын сургуулиудад ажиллалаа.

PISA 2022 олон улсын чанарын үнэлгээ судалгаа авах ажил сонгогдсон 9 сургууль дээр зохион байгуулагдлаа.

“ХҮҮХЭД БҮРТ ТЭГШ БОЛОМЖ-ЭЕШ 2022 СОРИЛ” 2 үе шаттай зохион байгуулагдлаа. Сорилд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн 32 ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12 дугаар ангийн 1400 гаруй суралцагч Математик, физик, хими, биологи, монгол хэл, англи хэл, нийгэм судлал судлагдахууны нэгдмэл агуулгын хүрээнд сорил өгч оролцлоо.

“Орон нутагт шинжлэх ухаан технологи инновацийг нутагшуулья” аян БШУЯ, Шинжлэх ухаан технологийн сан, Шинжлэх ухааны академи, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, орон нутгийн захиргаа, хувийн хэвшил, гарааны компанийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулав.

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас МУБИС-ийн Биеийн Тамирын Сургууль-тай жил бүр хамтран зохион байгуулдаг Хөвсгөл аймгийн биеийн тамирын багш нарыг чадавхжуулах сургалт амжилттай зохион байгуулагдлаа.

“Мэргэжлийн бүлэг-Хамтын хөгжил” зорилтот арга хэмжээний хүрээнд Хөвсгөл аймгийн математикийн багш нар ээлжит “ЦАХИМ СУРГАЛТ”-д хамрагдлаа. Математикийн мэргэжлийн багш нарт “Гурван-Эрдэнэ” багшийн дээд сургуулийн боловсролын судалгаа, арга зүйн тэнхимийн эрхлэгч н.Дайвий-Од “Магадлал комбинаторик” сэдвээр сургалт явуулж, онолын мэдлэг, чадварыг дээшлүүлж ажиллалаа.

Аймгийн засаг даргын "Эрхэм баян - Эрдэм" дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан "ХӨГЖЛИЙГ БҮТЭЭГЧ ХӨВСГӨЛ" багш, сурагчдын бүтээлийн уралдаан Ирээдүй сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Гадаад хэлний багш нарт МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн Англи хэлний тэнхимийн ахлах багш Ph.D Г.Чулуунгэрэл "Ээлжит хичээлийг зохион байгуулах нь", МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн Орос хэлний тэнхимийн багш Ph.D, дэд профессор З.Баярчимэг "Хэл соёлын асуудалд" сэдвээр онлайн сургалт явууллаа.

"Зөвийг хэвшүүлье" уриан дор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Сурагчийн аюулгүй байдалд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд "Ногоон гэрэл цагаан шугам-2022" тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого чиглэлээр 14 үйл ажиллагаа, сургалт, нөлөөллийн ажилд 562 хүүхэд, 423 насанд хүрэгч, 150 гэр бүл, 207 залуучууд хамрагдсан байна.

ГБХЗХГ-ын фейсбүүк хуудсаар дамжуулан 25 мэдээ мэдээлэл, 4 төрлийн зөвлөмж, 2 сэрэмжлүүлгийг цахимаар хүргэж нийт 270 хандалт авсан байна.

Гэр бүлийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 53 хүн үйлчлүүлсэн. Үүнээс хүүхэд 14 (эрэгтэй 11, эмэгтэй 3), насанд хүрэгч 39 (эрэгтэй 5, эмэгтэй 34) байна.

Тосонцэнгэл, Алаг-Эрдэнэ сумдад ажиллан 150 гэр бүл, 200 гаруй залуучуудад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

Хүүхэд, өсвөр үе, залуучуудын дунд "Тайван амьдрал танай гэрээс-2", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалт зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, мөн хэн нэгнээр бахархах үзлийг төлөвшүүлсэн.

Хууль тогтоомжийн шинэчлэл, урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хүн амын бүлгүүдэд чиглэсэн мэргэжлийн нийгмийн ажлыг үйлчилгээг үзүүлэх нэгдсэн арга зүйд суралцуулах, чадавхжуулах зорилгоор аймгийн нийгмийн ажилтны нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан ба, зөвлөгөөнд сумдын ЗДТГ-ын нийгмийн бодлогын болон хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эрүүл мэнд, сургуулийн нийгмийн ажилтан, аймгийн ШШГГ, Нэгдсэн эмнэлэг, Хилийн 0257-р анги, Ахмадын асрамж, үйлчилгээний төв, Политехникийн коллежид ажиллаж буй нийгмийн ажилтнууд 140 гаруй хүн оролцлоо.

Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, сургуулийн нийгмийн ажилтан, Мөрөн сумын багийн засаг дарга нарыг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх,

санхүүжүүлэх аргачлал, журмыг танилцуулж, нийгмийн ажлын мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн тусламжийн 108 утасны программ ашиглах арга зүйд суралцууллаа.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аян зохион байгуулав.

Оюун сэтгэхүй хөгжүүлэх хурдны гайхамшиг спорт өрөлтийг бүх насныханд сурталчлан таниулах, тус спортоор хичээллэж буй хүүхэд, өсвөр үеийнхний ур чадварыг нэмэгдүүлэх, дотоод болон гадаадын тэмцээн, уралдаанд оролцох шилдэг тамирчдыг тодруулж, ирээдүйн мэргэжлийн тамирчдыг бэлтгэх зорилготойгоор спорт өрөлтийн аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнийг Аймгийн Оюун ухааны академитай хамтран зохион байгуулав.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь 2021-2022 онд "ВОРЛД СТАНДАРТ КОНСАЛТИНГ"ХХК-тай хамтран Олон Улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнтэй уялдуулан 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн 3 дахь өдрийг ISO 9001:2015 стандартын хэлэлцүүлэгийн өдөр болгосон.

ХБӨ/Зүрх судасны өвчнөөс сэргийлэх хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлэх МонПЭН төслийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийхээр ЭМЯ, НЭМҮТ-ийн ЭМДӨУСА-ны ЭША, ДЭМБ-ын хамтарсан баг Хөвсгөл аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Алаг-Эрдэнэ СЭМТ, Энэрэл, Дэлгэрмөрөн, Далайн-Элбэрэлт ӨЭМТ-үүдэд ажиллаж байна. Дэмжлэгт хяналтаар цахим програм ашиглалт, танита аппаратыг хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөөг өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаа.

“Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд аймаг, сумдын удирдлага, аяныг хэрэгжүүлэгч байгууллагуудын 250 гаруй төлөөллүүдийг оролцуулсан “Нийтийн биеийн тамирыг эрчимжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөн Хөвсгөл аймагт зохион байгуулагдлаа.

Эрүүл мэндийн яам, Монголын Сувилагчдын Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж буй *Сувилагчаа сонсоё* хэлэлцүүлгийг Хөвсгөл аймагт амжилттай зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт ахмад сувилагчдын нийгэмлэг, Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн алба, арга зүйч, ахлах сувилагч, сум, өрх, хувийн хэвшлийн ЭМБ-ын ахлах сувилагч нар оролцож, сувилахуйн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэн, зохих түвшинд шийдвэрлүүхэд хамтран ажиллахаар боллоо.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга Д.Оюунбилэг Хөвсгөл аймагт ажиллаа. Ажиллах үеэрээ Аймгийн ЭМГ, НЭ, сум, өрх, хувийн хэвшлийн ЭМБ-уудын эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд

"Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулав.

"Сайн эмнэлэг-сэтгэлд нийцсэн үйлчилгээ" төслийг төрийн болон төрийн бус байгууллагынханд танилцуулах сургалтыг МАСАМ II төслийн багийнхан зохион байгуулж байгуулж байна.

Мөрөн сумын Засаг даргын 2022 оны 04 сарын 7-ны өдрийн А/55 тоот захирамжийн дагуу өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг, хорт зуршилаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Зөв дадал-Эрүүл бие" аяныг Мөрөн сумын ЕБС-ийн дунд ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 900 гаруй сурагчдад мэдээлэл сурталчилгааны ажлыг өрнүүлж байна. Сургалтыг Мөрөн сумын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Өрхийн ЭМТүүд хамтран зохион байгуулж байна.

Аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашины жолооч нарын амилуулах суурь тусламжийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах, автомашины бэлэн байдлын үзлэг хийх, жолооч нарын хариуцлагын гэрээний хэрэгжилтийг үнэлэх дадлага сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Тус сургалтад 23 сум, 5 өрхийн ЭМТ болон аймгийн нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн жолооч нар хамрагдлаа.

Хөвсгөл аймагт НҮБ-ын Хүүхдийн сангийн Шадар суурин төлөөлөгч Аяако Кайно Боловсролын ахлах мэргэжилтэн Н.Цэрэннадмид, Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Мөнхжаргал, Төсвийн асуудал хариуцсан ажилтан Б.Мөнх-Эрдэнэ, орон нутгийн хөгжил хариуцсан мэргэжилтэн Б.Зоя нар ажиллаж Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн ажлын байранд эх хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаатай танилцсан. Аймгийн хэмжээнд хэрэгжсэн Хүүхдэд ээлтэй аймаг хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах бодлого стратеги, түүний хэрэгжилттэй удирдлагуудын түвшинд хэлэлцүүлэг хийгдлээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Гэмтэл согог судлалын үндэсний төв аймгийн Эрүүл мэндийн газар хамтран эрүүл мэндийн байгууллагын 80 эмч мэргэжилтэн, зорилтод бүлгийн албан хаагч буюу Онцгой байдлын 15, Цагдаагийн газрын 15 албан хаагч, Улаан загалмайн хорооны 6 сайн дурын ажилтан, сургууль цэцэрлэгийн 14, аймгийн нийтийн тээврийн 3 хоршооны 13 жолооч, Зоонозын өвчин судлалын төвийн 3 албан хаагч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн 1 албан хаагч нарт "Осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, Хүчирхийллээс сэргийлэх цогц сургалтыг зохион байгууллаа.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

WAIS программаар 5960 иргэнд 217 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг олгосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ehalamj.mn-ээр 14937 иргэнд 1.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон. "Хөдөлмөрөөс-Халамжид"-д зорилтын хүрээнд Рэнчинлхүмбэ сум хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй 3 дахь сум болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 4 сард 2 удаа хуралдаж 34 хүүхдийн асуудлыг авч хэлэлцсэн. Байнгын асаргаанд байдаг 23 хүүхдийн хүүхдийн асаргааг сунгаж, шинээр 6 хүүхдийг асаргаанд хамруулсан бол 5 хүүхдийн асаргааг онош тохирохгүй үндэслэлээр зогсоосон.

Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Дэлхийн зөн ОУБ-ын Хөвсгөл ОНХөтөлбөр, Хөвсгөл аймгийн хувцас захиалга, гар урчуудын холбоо болон оёдолчдын нэгдсэн холбоотой хамтран Хөгжимт драмын театрт 200 иргэнийг хамруулан Оёдолчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд аймгийн нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлэх ажил, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2022 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн танилцууллага хийж, өмнө жилүүдэд ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдаж санхүүжилт авсан иргэдийн бүтээлийг дэлгэн сонирхуулсан.

Мөн 4 сард 42 иргэнийг ажилд зуучлагдаж орсон, 248 иргэнийг идэвхтэй ажил хайгчаар бүртгэн, шинээр 87 ажлын байр бүртгэгдсэн байна. Үүнээс байнгын ажлын байр 52, улирлын-5, түр 30 ажлын байр тус тус бүртгэсэн.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд “ Илүүдэл жингүй –Эртэч иргэнтэй Хөвсгөл” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аяны нээлтийн үйл ажиллагаа энэ сард зохион байгуулагдлаа.

“Нийтийн биеийн тамирыг эрчимжүүлэх нь” зөвлөгөөнд Сумын засаг дарга, сумдын орон тооны болон орон тооны бус арга зүйчид, нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, биеийн тамирын багш, албан байгууллагын орон тооны болон орон тооны бус арга зүйчид, ахмадын чийрэгжилтийн төвийн ахмадууд , цэцэрлэгийн биеийн тамирын багш нар арга зүйчид нийт 255 гаруй хүн хамрагдлаа.

“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд аймгийн засаг даргын захирамж гарч албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд хуваарь гарган өглөө бүр 6:30, 7:30 хооронд заалуудад дасгал хөдөлгөөн хийгдэж, давхардсан тоогоор 90000 мянга гаруй хүн хамрагдаад байна.

Хүндийн өргөлтийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 20 байгууллагын 200 гаруй тамирчид оролцож хүч чадал, тэсвэр тэвчээр, авхаалж самбаагаа сорин нийт эрэгтэй 12, эмэгтэй 12 тамирчид оролцлоо.

Монгол Улсын Аварга, Спортын мастер Нямаагийн Төрбат-ын нэрэмжит “Цодгор хүү” шатрын улсын аварга шалгаруулах 30 дахь удаагийн тэмцээнд нийт 21 аймаг 9 дүүргийн 200 гаруй хүүхэд оролцсон. Уг тэмцээнд Хөвсгөл аймгаас 8 хүүхэд оролцож 2 хүрэл медаль, 1 тусгай байрын шагнал хүртлээ. Тусгай байрын шагналд Монголын хүүхдийн ордны Алдар алтан медалиар шагнагдсан.

Өсвөрийн шатарчдын Улсын аварга шалгаруулах тэмцээн Багануур дүүрэгт зохион байгуулагдлаа. Нийт 49 байгууллагын 680 гаруй хүүхэд оролцсон. Тэмцээнд Хөвсгөл аймгаас 28 хүүхэд амжилттай оролцлоо. Тусгай байр 4 хүүхэд хүртлээ.

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах Бадминтоны тэмцээнд 10 аймаг 3 клубын нийт 364 тамирчин 99 медалын төлөө хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шилдэгүүдээ тодрууллаа.

2022 оны Насанд хүрэгчдийн Аймгийн аварга шалгаруулах Бадминтоны тэмцээнд 9 байгууллагын 60 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шилдэгүүдээ шалгарууллаа.

Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээн 10-11 нас, 12-13 нас, 14-15 нас, 17-18 нас задгай төрлөөр нийт 18 байгууллагын 300 гаруй хүүхэд оролцлоо.

Аймгийн аварга шалгаруулах Уулын дугуйн тэмцээнд 7 байгууллагын 50 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин уралдлаа. Тэмцээнд 1-р байр Титэм ЕБС, 2-р байр Дэлгэр Мөрөн цогцолбор сургууль, 3-р байр Тариалан сум тус тус орлоо.

Зургаа мал аж ахуй, газар тариалан, хаваржилтийн талаар:

Төл бойжилт: 2022 оны 04 сарын 28-ний байдлаар: Мал төллөлт оны эхний 2632722 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 995414 толгой хээлтэгч төллөсөн. Үүнээс ингэ-77, гүү-11056, үнээ-36623, эм хонь-604201, эм ямаа-343457 мал төллөж байна. Хээл хаясан хээлтэгч нийт 2004 толгой, гүү-10, үнээ-90, эм хонь-824, эм ямаа-1080 толгой байна. Хорогдсон төл нийт 13166 толгой, унага-131, тугал-439, хурга-6120, ишиг-6476 толгой төл мал хорогдсон байна.

Төлөлтийн хувь 41.2 хувьтай, төл бойжилт 98 хувьтай байна. Мал төллөлтийн хувь хамгийн өндөр байгаа сум Бүрэнтогтох-60.8%, Рашаант-57.2%, Галт-56.2%, Жаргалант-64.6%-тай төллөж байна. Оны эхний 5943214 толгой том малаас нийт 7423 толгой хорогдсон байна. үүнээс: адуу 374, үхэр 811, хонь 3396, ямаа 2842 мал хорогдож оны эхний нийт малаас 0.12 хувь нь хорогдсон байна.

“Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацийг нутагшуулъя” аяны хүрээнд “Өндөр уулын бүсэд үхэр, хонины мах үйлдвэрлэлийг богино хугацаанд нэмэгдүүлэх боломж”, “Мах, сүүний үхрийн фермийн үржлийн ажил, тэжээллэг, арчилгаа маллагаа, эрүүл мэнд”, “Малчдын түвшинд малын тэжээл тариалах арга технологи”, “Зохиомол хээлтүүлгийг үр ашигтай хөтлөн явуулах боломж” зэрэг сэдвүүдээр Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн багш Доктор Д.Гүрбазар, Доктор Г.Энх-Манлай нартай хамтран 24 сумын ХААТ-ийн мэргэжилтнүүд болон Мөрөн, Түнэл, Бүрэнтогтох сумдын фермерүүдийг оролцуулсан сургалтыг зохион байгууллаа.

2022.04.01 нд Тосонцэнгэл суманд Газар тариалан эрхлэгч, хоршоологчид сургалт зохион байгуулж мэргэжилтэн Б.Лхагвадулам “Хоршоо салбарын танилцуулга, хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга” Газар тариалан

хариуцсан мэргэжилтэн Б.Цолмонбаяр “Хөвсгөл аймгийн газарт тариалангийн өнөөгийн байдал цаашдын зорилт” сэдвээр мэдээлэл хийсэн.

2022.04.14 нд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Хатгал тосгонд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Лхагвадулам “Төсөл бичих аргачлал, Хоршооны хууль, бүртгэл, хоршооны зээл”-ийн талаар зөвлөгөө өгсөн.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд "Өрхийн тариалан-2022" хөдөлгөөн өрнүүлэх, газар тариалангийн салбарт дэвшүүлсэн бодлогын зорилтыг тодорхойлох, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, төмс хүнсний ногооны дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилгоор сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд Мөрөн, Бүрэнтогтох, Тосонцэнгэл суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, ААН-ийн 180 гаруй хүн хамрагдлаа.

Мөрөн сумын “Оёдолчдын анхдугаар зөвлөгөөн”-ийг Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Дэлхийн зөн ОУБ-ын Хөвсгөл ОНХөтөлбөр, Хөвсгөл аймгийн Хувцас захиалга, гар урчуудын холбоо болон Оёдолчдын нэгдсэн холбоо хамтран 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хөгжимт драмын театрт 200 иргэнийг хамруулан зохион байгууллаа.

2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 118 дугаар тогтоолын дагуу Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд 2022 оны хаврын тариалалтад зориулан улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан төмс, хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үрийн үнийг 80 хувийн хөнгөлттэйгээр шар лууван үр-50 кг, шар манжин үр-10 кг, хүрэн манжин үр-10 кг, тарвасын үр-1 кг, бууцайны үр-2 кг, сармисны үр-200 кг, лооль үр-0.05 кг, хүлэмжийн өргөст хэмх-1000 ш, байцааны үр-15000ш, чинжүүний үр-1 кг, урт сонгины үр-10 кг ХХААХҮЯ-аас хүлээн авч таталт хийн 18 сумын 163 өрхөд олголсон.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЭГ)-ын даргын А/187 дугаар тушаалаар баталсан “Шүлхий өвчинтэй тэмцэх заавар”, Улсын онцгой комисс (УОК)-ын 02 дугаар тогтоол, УОК-ын шуурхай штабын 2022 оны 3-р сарын 28-ны өдрийн 330, МЭЭГ-ын даргын 2022 оны 3-р сарын 3-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай”, 2022 оны 4-р сарын 8-ны өдрийн А/77 дугаар тушаал “Шүлхийн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай”, Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах Стандарт Ажиллагааны Зааварчилгаа (САЗ), Аймгийн засаг даргын 2022 оны 4-р сарын 14-ын өдрийн “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/117 дугаар захирамж, Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээний хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж,

МЭЕГ-ын даргын 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн А/08 тоот тушаалын дагуу шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг 2022 оны 4-р сарын 18-ны өдөр Хөвсгөл аймгийн хэмжээнд эхлээд байна. 2022 оны 4-р сарын 11-ны өдөр МЭЕГ-аас ОХУ-д үйлдвэрлэсэн Шүлхийн өвчний А, О дэд хэвшлийн СТО 050222 цувралын дугаартай 532,0 мянган тун 436470,3 сая төгрөгийн вакцин нийлүүлэгдэж вакцины тэмдэглэгээний код болох 20-01-ээс 20-23 хүртэл дугаарласны дагуу 23 сум, 1 тосгоны 74 аж ахуйн нэгжид хуваарийн дагуу хөргүүртэй машинаар түгээлт хийн зориулалтын хөргүүрт нь хийсэн. Вакцин түгээлтийн ажил 4-р сарын 17-ны өдөр дуусч, уг ажилд 23 сум 1 тосгоны 125 багт ажлын 105 хэсэгт 594 хүн ажиллаж байна. Үүнд удирдах ажилтан - 129, малын эмч - 121, техникч - 51, туслах ажилтан буюу мал баригч - 204, жолооч - 94 байна. Аймгийн хэмжээнд нийт 504,5 мянган толгой үхэр, 2448 толгой цаа буга, 534 толгой гахай таригдахаас өнөөдрийн байдлаар 13985 өрхийн 474156 үхэр, 512 гахайг, цаа буга 2140 нийт 476808 толгой мал, амьтан хамрагдаж нийт малын 93.3 хувийг вакцинжуулалтанд хамруулаад байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР:

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулах нээлттэй хаалганы өдрийн бэлтгэл, санал авах зөвлөлдөх уулзалтад оролцож нээлттэй хаалганы өдрөөр иргэдэд үзүүлэх үйлчилгээний саналыг хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын Байгаль орчин, ХАА-н байгын хороонд аймгаас гадагш гаргах модны үлдэгдлийн талаар танилцуулав.

2022 оны 12 сарын 30-ны өдрийн аймгийн Засаг даргын А/657 дугаартай захирамжаар байгуулагдсан “Хоггүй Хөвсгөл” нэгдсэн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 11-нээс 04 дүгээр сарын 14-нийг хүртэл Улаанбаатар хотод хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн холбоод, ТББ, төсөл хөтөлбөрүүдтэй туршлага судлах уулзалт зохион байгуулж хог хаягдал дахин боловсруулах “Пластик центр” ХХК, “Эко цаас” ХХК, “Ти эм эл реисайклинг” ХХК-ийн үйл ажиллагаа болон Цагаан давааны хогийн цэгийн үйл ажиллагаатай танилцсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнтэй хамтран “Хог хаягдлын менежмент” сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 09.00- 18.00 хүртэл Соёмбо танхимд зохион байгууллаа. Уг сургалтын хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, доктор Л.Жаргалсайхан, Органик химийн лабораторын эрхлэгч Б.Хулан, Материал судлал, технологийн лабораторийн эрхлэгч, доктор Г.Оюун-Эрдэнэ, Геохимийн лабораторийн эрхлэгч, доктор М.Баяржаргал нар дараах агуулгын хүрээнд хичээл заалаа. Дээрх сургалтад нийт 97 хүн хамрагдсан.

“Бүх нийтийн цэвэрлэгээ хийх удирдамж”, “Бүх нийтийн цэвэрлэгээний тайлан ирүүлэх загвар хүснэгт”-ийг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн Засаг даргын А/120 дугаартай “Ажил зохион байгуулах тухай” захирамжаар баталгаажуулан сумын Засаг дарга нарт “Бүх нийтийн цэвэрлэгээ”-г 2022 оны 04

дүгээр сарын 23-наас 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулах чиглэл өгсөн.

БОАЖ-ын сайд Б.Бат-эрдэнэ, АЖБЗГын дарга н.Болортуяа, ТХНУГ-ын дарга Д.Батмөнх нар 4 дүгээр сарын 16,17 ны өдөр манай аймагт томилолтоор ажиллаж аймгийн байгаль орчны салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, Хатгал тосгон , ХНБЦГ-т ажиллалаа. Мөн уснаас татаж гаргасан Сүхбаатар хөлөг онгоцтой танилцаж, нуурын усанд живсэн машины байршлын талаар мэдээлэл сонсож, санал солилцлоо. Ажлын хэсэгтэй ХНЭГСГ-ын захиргааны дарга И.Найманжин, мэргэжилтэн Д.Дуламсүрэн, Д.Оргилбаатар нар хамтран ажиллалаа.

“Аялал жуулчлалын менежмент төлөвлөгөө”-г төсөл хэлбэрээр боловсруулж аймгийн Засаг даргад 4 дүгээр сарын 08-ны өдөр танилцууллаа.Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 12 дугаар хуралдаанаар 2023 оныг “Хөвсгөлд зочлох жил” болгон зарлах тухай мэдээлэл бэлтгэн оруулж хурлын төлөөлөгчдийн олонхийн саналаар дэмжигдлээ.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА